



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/33

Ховд

Агуулахын газрын байнгын
байршил тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн “г” дахь заалт, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Булган стар” ХХК-нд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хадгалах агуулахын газрын байнгын байршлыг Мөст сумын Хужирт багийн Нарийн дав хэмээх газарт тогтоож, тухайн газрын солбицлуудлыг хавсралтаар баталсугай.

2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хадгалах агуулахын байранд “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” болон бусад холбогдох хууль, журмын хүрээнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /П.Эрдэнэчулуун/-д даалгасугай.

3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хадгалах агуулахын байранд “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг баримталж, холбогдох газруудад тайланг мэдээг хүргүүлж, агуулахын газрын байнгын байршлыг мэдээллийн нэгдсэн санд хуулийн хугацаанд бүртгүүлэхийг “Булган стар” ХХК-ний захирал /Н.Алтанзул/-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповронд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ




Т.ЖАРГАЛСАЙХАН

Zax A/33 Ch

02 00150

Аймгийн Засаг даргын 2020 оны
01 дүгээр сарын 28-ны өдрийн
А/33 дугаар захирамжийн хавсралт



ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙГ
ХАДГАЛАХ АГУУЛАХЫН ГАЗРЫН БАЙНГЫН БАЙРШИЛ

№	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	92	25	43,7	46	27	46,7
2	92	25	43,713	46	27	48,173
3	92	25	38,9	46	27	49,5
4	92	25	38,9	46	27	46,7

-оОо-